



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 27 өдөр

Дугаар 26

Хэрлэн сум

XXVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 26 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 12:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 89,2 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.МУ-ын Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, тус яамны төрийн нарийн бичгийн даргад “Эхний ээлжинд нэн шаардлагатай эрүүл мэндийн ажилтнууд, хилийн боомт, хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид, ачаа тээврийн жолооч нарыг вакцинжуулалтад хамруулж өгөхийг хүссэн хүсэлт” албан бичгийн төслийг танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2.Аймгийн Онцгой комиссоос томилогдсон ажлын хэсэг сумдад ажилласан тухай мэдээлэл танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

3.Ачаа тээврийн жолооч нарыг байрлуулах нэгдсэн тусгаарлах байр гаргах тухай санал хэлэлцэх,

*Мэргэжлийн хяналтын газар
Авто тээврийн төв*

4.Хөлөнбуйр хяналтын цэг болон бусад хяналтын цэгүүд, сумдын Онцгой комисст “Улсын Онцгой комиссын 2021 оны 10 дугаар хуралдааны хөдөлгөөн хориглосон шийдвэрийг мөрдөж ажиллах тухай” чиглэл хүргүүлэх албан бичгийн төсөл танилцуулах, мөн сумд болон Хөлөнбуйр хяналтын цэгийн албан хаагчидтай цахим хурлыг зохион байгуулж чиглэл өгөх тухай

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

5.Карго тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийн автомашин нэмэгдүүлэх хүсэлтийн дагуу тус аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалтын дүнг танилцуулах,

*Авто тээврийн төв, Мэргэжлийн хяналтын газар
Эрүүл мэндийн газар*

6.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

Ca /М.Бадамсүрэн
Ж.Баттулга /Д.Баттулга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

1.1.Аймгийн Онцгой комисс, шуурхай штабын гишүүд гүйцэтгэх ажиллагаанд оролцохгүй байх, хувийн халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлах, хариуцлагаа дээшлүүлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

1.2.Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, тус яамны төрийн нарийн бичгийн даргад "Эхний ээлжинд нэн шаардлагатай эрүүл мэндийн ажилтнууд, хилийн боомт, хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид, ачаа тээврийн жолооч нарыг вакцинжуулалтад хамруулж өгөхийг хүссэн хүсэлт" албан бичгээр хүргүүлэх,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.1.Сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудад мэргэжил арга зүйн зөвлөмж олгох сургалтыг зохион байгуулах, бэлэн байдлыг хангуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:



2.2.Агентлагуудаас сумдад ажлын хэсэг томилогдон ажиллахдаа заавал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст мэдэгдэн зөвшөөрөл авах, хуваарийн дагуу ажиллуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа, Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

2.3.Сумд Улаанбаатар хотоос хүнсний тээвэрлэлт хийхдээ зохион байгуулалтаар хангах, хариуцлагын гэрээ байгуулах, халдвар хамгааллын дэглэмийг баримталж Хөлөнбуйр сумын хяналтын цэгээс хяналттайгаар тухайн сум руу шууд нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.4.Аймгийн Онцгой комисс, Шуурхай штабын шийдвэрээр зарцуулах, байнгын бэлэн байдлыг хангах зорилгоор 14 сумын аюулгүйн нөөцөд байршуулах коронавирус илрүүлэх 25 ширхэг түргэвчилсэн оношлуур худалдан авахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,


/М.Бадамсүрэн

/Д.Баттулга

2.5.Эрүүл мэндийн яамнаас аймгийн Эрүүл мэндийн газарт өгсөн чиглэлийн дагуу шаардагдах аюулгүйн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах талаар 14 сумын Засаг дарга нарт үүрэг хүргүүлэхийг,

2.6.Уул уурхайтай холбоотой асуудлыг аймгийн Шуурхай штаб, сумын Онцгой комиссын саналыг үндэслэн цаашид шийдвэрлэхийг,

2.7.Гэрийн тусгаарлан ажиглалтад байгаа иргэдийн мэдээллийг “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-т хүргүүлэх,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

2.8.Сумдын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвд гар ариутгагч, зайнаас халуун хэмжигчтэй болох талаар сумдын Засаг дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэх,

2.9.Сумдад халдвар хамгааллын хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах талаар саналыг боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Гурав.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр

3.1.Ачаа тээврийн компаниудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж гэрийн тусгаарлан ажиглалтын байрны асуудлын талаар хэлэлцэж шийдвэрлэх,

3.2.Ачаа тээврийн жолооч нарыг гар утасны байршлаар хянах ажилд албан хаагчийг томилох,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

3.3.“Хан цайз” ХХК-ийн тээвэрлэлтийг тус компанийн саналын дагуу 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд үйл ажиллагааг түр зогсоох,


Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.4.Барилгын материал тээвэр, хүнс тээвэр, эм эмнэлгийн хэрэгсэл, карго тээвэр, мал, өвс тэжээл тээвэрлэлт, уул уурхайн ачаа тээвэр, буяны ажлын тээвэрлэлтийг хянах, зохион байгуулалтаар хангах 6 ажлын хэсэг байгуулах аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Дөрөв.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

4.1.Шөнийн цагаар иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх талаар ажил зохион байгуулах,


/М.Бадамсүрэн
/Д.Баттулга

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын
дарга Н.Мөнхгэрэл нарт:

4.3.Уламжлалт эмнэлэг, Ахмадын сувилалд хэвтэн эмчлүүлж буй иргэдийг түүврийн аргаар тандалтын шинжилгээнд хамруулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА